



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 1250

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.4, 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бизнес хөгжлийн, түрээсийн байрны засварын ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батдорж (Засаг даргын орлогч)

Гишүүд: Э.Бадамханд (Жижиг дунд үйлдвэр хоршоо

хариуцсан мэргэжилтэн)

Д.Бадамбаяр (Иргэний төлөөлөл)

Ж.Алтангэрэл (2 дугаар сургуулийн нярав)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын

нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан нөхцөл хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батдорж)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

